



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэсний статистикийн хорооны харьяа Статистикийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 3 нэрийн, нийт 86,800,000.00 (наян зургаан сая найман зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагва, Статистикийн хэлтсийн дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Орон нутгийн өмчийн газрын төлөөлөгчийг оролцуулан, үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000341
5-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 02 дугаар сарын 26-ны/ний өдрийн
109 дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Автомашин эзэмшигч байгууллагын нэр	Хөрөнгийн нэр, төрөл, арал, улсын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Дуудлага худалдаагаар худалдах доод үнэ (төгрөг)
1	Дорноговь аймаг дахь Статистикийн хэлтэс	0714ДГО, FZJ800157990 арлын, 0714ДГО улсын дугаартай	1996/2005	30,000,000.00	5,000,000.00
2	Завхан аймаг дахь Статистикийн хэлтэс	Тоёото Ланд круйзер 80, , FZJ8001135830 арлын, 01483АН улсын дугаартай	1995/2010	46,800,000.00	5,000,000.00
3	Өвөрхангай аймаг дахь Статистикийн хэлтэс	Тоёото Ланд круйзер 80, , FZJ800131223 арлын, 6210ӨВР улсын дугаартай	1996/2005	10,000,000.00	5,000,000.00
НИЙТ ДҮН				86,800,000.00 (наян зургаан сая найман зуун мянга)	15,000,000.00 (арван дөрвөн сая)